

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/02/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.govisumberaudit.mn Чойр хот 2022 он	Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 261663 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 261885 Цахим хаяг: naranbayarg@ audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Батсайхан Утас: 261740 Цахим хаяг: batsakihants@ audit.gov.mn Аудитор: Утас: 260512 Цахим хаяг: Гэрээгээр гүйцэтгэсэн Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн Захирал Ш.Ичинхорлоо Утас77280808 Цахим хаяг:
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	8
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
4.1 Байгууллагын үйл ажилагаа	8
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	8
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
8. Аудитын илрүүлэлт.....	12
8.1 Залруулсан алдаа.....	12
8.2 Төлбөрийн акт	12
8.3 Албан шаардлага.....	12
8.4 Зөвлөмж.....	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт

“УС- ДУ” ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ

Б.ГАНЗОРИГ ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 470 дугаар тогтоолоор дулааны эрчим хүчний тарифыг шинэчлэн тогтоосон ба Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 50 дугаар тогтоолоор цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг тус тус шинэчлэн баталсантай холбоотойгоор аймгийн эрчим хүч, бохир, цэвэр усны үнэ тариф шинэчлэгдсэн байна.

Аудитын гол асуудлууд

Монгол Улсын Засгийн газраас 2021 онд айл өрх, ААНБ-уудын дулаан, цэвэр бохир усны хөнгөлөлт чөлөөлөлтөд нийт 800.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 624.7 сая төгрөг олгож, 175.7 сая төгрөгийг олгоогүйгээс авлага үүссэн байна. Нийт санхүүжилтийн 800.5 сая төгрөгөөс дулаан 488.8 сая төгрөг нь цэвэр бохир ус 311.7 сая төлбөр байна.

/АОУС 701-ийн шаардлагын дагуу аудитын гол асуудал бүрийн тайлбар/

Бусад асуудал

Бусад мэдээлэл

2021 оны жилийн эцэст аймгийн халаалтын шугаманд холбогдсон нийт 1094 айл өрх 16 төсвийн байгууллага 37 ААНБ, нийт 1147 хэрэглэгчид нийт 23524 гкал дулаан үйлдвэрлэн түгээсэн.

Тайлант онд цэвэр ус 134584м³ ус борлуулсан, бохир ус 118480м³ ус татан зайлуулж ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.САРАНТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
2	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	-
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	120,745,426.98	2,905,332.43
4	Дансны авлага	348,168,810.46	272,559,671.45
5	Бараа материал	67,352,209.85	91,979,901.40
6	Бусад эргэлтийн хөрөнгө	7,255,000.00	0.0
7	Эргэлтийн хөрөнгийн дүн	136,481,665.08	136,939,436.43
8	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	549,024.371.03	373,385,829.68
9	Үндсэн хөрөнгө	5,685,270,635.41	9,057,001,810.20
10	Биет бус хөрөнгө	0.0	4,264.00.00
11	Бусад биет бус хөрөнгө (Газар)	0.0	0.0
12	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,685,270,635.41	9,061,265,810.20
13	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,234,295,006.44	9,434,651,100.88
14	Татварын өглөг	48,767,262.21	67,628,067.58
	НДШ-ийн өглөг	44,063,675.86	0.00
15	Бусад өглөг	378,494,789.76	150,901,752.47
16	Урьдчилж орсон орлого	2,184,654,274.00	5,616,826,271.44
17	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,655,980,001.83	5,839,130,313.57
18	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
19	Өр төлбөрийн нийт дүн	2,655,980,001.83	5,839,130,313.57
20	2. Эзэмшигчдийн өмч	1,349,873,387.25	1,349,873,387.25
21	Өмч: а) төрийн	1,349,873,387.25	1,349,873,387.25
22	б) хувийн	0.00	0.00
23	Дахин үнэлгээний нөөц	632,846,588.92	706,915,842.92
24	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	3,498,022,951.78	3,495,997,951.78
25	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-1,902,427,923.34	-1,957,266,394.64
26	Эзэмшигчдийн өмчийн дүн	3,578,315,004.61	3,595,520,787.31
27	Үүнээс: Цөөнхийн хувь оролцоо	-	-
28	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	6,234,295,006.44	9,434,651,100.88

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,247,693,816.72	2,078,621,712.00
2	Борлуулалтын өртөг	1,512,074,635.55	1,993,954,512.33
3	Нийт ашиг	-264,380,818.83	84,667,199.67
4	Бусад орлого	195,815,171.00	208,644,624.01
5	Түрээсийн орлого	0.00	18,181,818.19
6	Ерөнхий ба удирдлагын зардал	164,900,945.49	253,459,038.70
7	Санхүүгийн зардал	32,329,256.00	0.00
8	Бусад зардал	38,763,199.57	192,557.86
9	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(355,720,426.66)	(54,838,471.30)
10	Орлогын татварын зардал	0.00	0.00
11	Татвар дараах ашиг (алдагдал)	(355,720,426.66)	(54,838,471.30)
12	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(355,720,426.66)	(54,838,471.30)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020.12.31 үлдэгдэл	1,349,873,387.25	632,846,588.92	3,498,022,951.78	1,902,427,923.34	3,578,315,004.61
Тайлант оны үеийн үр дүн		74,069,254	(2,025,000)	(54,838,471.3)	(54,838,471.3)
2021.12.31 үлдэгдэл	1,349,873,387.25	706,915,842.92	3,495,997,951.78	(1,957,266,394.64)	3,595,520,787.31

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2	Мөнгөн орлогын дүн (+)	1,768,971,549.49	2,094,857,646.68
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,557,076,791.49	1,543,692,489.02
4	Туслах үйл ажиллагааны мөнгөн орлого	211,894,758.00	551,165,157.00
5	Мөнгөн зарлагын дүн (-)	1,635,533,464.89	2,212,587,741.23
6	Ажиллагчдад төлсөн	401,194,236.76	461,103,994.94
7	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	85,922,525.04	206,249,045.57
8	Бараа материалын худалдан авахад төлсөн	564,686,079.9	672,304,207.84
9	Ашиглалтын зардалд төлсөн	212,702,783.60	234,425,488.02

	Түлш, шатахуун, тээврийн хөлсөд төлсөн	255,208,845.00	84,557,427.00
	Зээлийн хүүгийн төлбөр	14,318,000.00	10,867,493.15
10	Татварын байгууллагад төлсөн	33,221,686.68	176,919,350.14
	Даатгалын төлбөр	4,630,762.00	4,433,437.00
	Бусад манган зарлага	63,648,545.91	361,727,297.57
11	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	133,438,084.60	(117,730,094.55)
	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	7,159,000.00	110,000.00
	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,159,000.00)	(110,000.00)
	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	50,113,000.0	0.00
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(50,113,000.0)	0.00
12	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	76,166,084.60	(117,840,094.55)
13	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	44,579,342.38	120,745,426.98
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	120,745,426.98	2,905,332.43

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих хэгж	2020 оны гүйцэтгэл	2021 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Дулаан	төг	862,214,696	892,157,272	1,084,647,477	192,490,205	1.2
	Цэвэр ус	төг	136,943,526	237,211,120	245,071,495	7,860,375	1.0
	Бохир ус	төг	92,930,163	133,730,000	142,235,987	850,987	1.1
	ХХУ	төг	49,023,675	46,805,760	62,237,993	15,432,233	1.3
	Хөрөнгө оруулалт	төг	41,898,490	300,000,000	476,360,489	176,360,489	1.6
	Туслах аж ахуй	төг	4,067,399	5,000,000	10,916,364	-5,916,364	2.2
	Засвар үйлчилгээ	төг	45,333,583	10,000,000	9,049,723	950,277	0.9
	УОО	төг	195,815,100	205,815,171	208,413,192	-2,598,021	1.0
	Бусад	төг	15,282,283	0	66,515,435	-66,515,435	
	Нийт орлогын дүн	төг	1,443,508,915	1,830,719,323	2,305,448,155	-474,728,832	1.3
	Үүнээс: Цэвэр Борлуулалт	төг	1,190,513,042	1,324,904,152	1,554,159,039	-229,254,887	1.2
	Нийт зардал	төг	1,799,229,413	2,484,150,099	2,360,309,759	123,840,340	1.0
2	ББӨ	төг	1512074636	2022227763	2,004,763,903	17,463,859.6	1.0
	Ерөнхий ба удирдлагын зардал	төг	164,900,945	346,049,936	242,649,639	103,400,297	0.7
	Борлуулалтын зардал	төг	122,253,832.6	115,872,400	112,896,217	2,976,182.91	1.0
	Цэвэр шиг алдагдал	төг	-355,720,426.7	(653,430,776)	(54,861,604)	-598,569,172	0.1
	Нийт ашиг алдагдал	төг	(355,720,427)	(653,430,776)	(54,861,604)		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад төлөвлөсөн зардлын зарцуулалт, төлөвлөлттэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн ахлах аудитор Ц.Энхтуяа, гүйцэтгэж, анх шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны чанарын хяналтыг төрийн аудитын менежер Г.Наранбаяр, дарга. Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар гүйцэтгэв.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-д 2021 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 31 дүгээр албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг шинэчлэн, захирлын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/02 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлуулан ажиллаж, төлөвлөгөөт шалгалтыг 12 удаа, төлөвлөгөөт бус шалгалтыг 11 удаа хийсэн байна.

2021 оны дотоод хяналт шалгалтын ажилтны төлөвлөгөө болон дотоод хяналт шалгалтын календарчилсан төлөвлөгөө Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 сарын 31-ны байдлаарх 2,094.9 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 42.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын зорилгоо “Шинэ техник технологи, чадварлаг боловсон хүчнээр ус хангамж, ус цэвэрлэгээ, дулаан хангамжийн үйлчилгээг хэрэглэгчдэд чанартай найдвартай хүргэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Дулааны эрчим хүч үйлдвэрлэх хэрэглэгчдэд түгээх, цэвэр ус олборлох, хэрэглэгчдэд шаардлага хангасан цэвэр ус түгээх, бохир усанд анхан шатны цэвэрлэгээ хийж зайлуулах, хэрэглэгчдийн захиалгаар засвар үйлчилгээ хийх” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “уур үйлдвэрлэл, дулаан хангамж, ус хуримтлуулан ариутгаж, түгээх үйл ажиллагаа” статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь аймгийн Засаг даргын 1997оны А/10 дугаар тушаал /тогтоол/-ыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь төлөөлөн удирдах зөвлөл байхгүй бөгөөд аймгийн Засаг даргатай тайлант оны үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд аймгийн ИТХ-ын тогтоолоор арга хэмжээ авсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг үнэ тарифт дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 470 дугаар тогтоолоор дулааны эрчим хүчний тарифыг шинэчлэн тогтоосон,
- ✓ Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 50 дугаар тогтоолоор цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг тус тус шинэчлэн баталсантай холбоотойгоор аймгийн эрчим хүч, бохир, цэвэр усны үнэ тариф шинэчлэгдсэн байна.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	120.7	2.9	(118.0)
Авлага	353.7	278.5	(75.2)
Бараа материал	67.3	92.0	24.6
Бусад эргэлтийн хөрөнгө	7.2	0.00	(7.2)
Үндсэн хөрөнгө	5,685.3	9,057.0	3,371.7
Биет бус хөрөнгө	0.00	4.3	4.3
Нийт хөрөнгийн дүн	6,234.3	9,434.6	3,200.3
Өр төлбөрийн дүн	2,656.0	5,839.1	3,183.1
Богино хугацаат өглөг	2,656.0	5,839.1	3,183.1
Урт хугацаат өглөг	0.00	0.00	0.00
Эздийн өмч	1,349.9	1,349.9	0.00
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,234.3	9,434.6	3,200.3

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд банкин дахь харилцах дансанд байгаа 2.9 сая төгрөг байна.

Авлагын дансны үлдэгдэлд дараах авлагууд бүртгэлтэй байна. Үүнд: ААНБ-аас авах 17.5 сая, айл өрхөөс авах 4.6 сая, Засгийн газраас 175.7 сая, ажиллагсдаас авах 0.06 сая төгрөгийн авлага тус тус байна.

Тайлант онд Засгийн газраас айл өрх, ААНБ-ын дулаан, цэвэр, бохир усны хөнгөлөлт, чөлөөлөлтийн санхүүжилтийг олгосон ажлын хүрээнд үүссэн Засгийн газраас авах авлага 175.7 сая төгрөг буюу 63.1 хувийг эзэлж байгаа нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэл хугацаандаа байгаа ба хугацаа хэтэрсэн авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 92.0 сая төгрөг болж 24.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд бэлтгэсэн бараа материалын үлдэгдэлтэй холбоотой байна.

Тайлант онд худалдан авсан 1,041.3 сая төгрөгийн орон сууцны, зуухны, хангамжийн материал зэрэг хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,371.7 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үүнд: Шинээр 12.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дугаар 56 тогтоолын дагуу 26.3 сая төгрөг, аймгийн ИТХ-ын 2021 оны 11 дугаар сарын 29-ны өдрийн дугаар 40 тогтоолын дагуу 15.3

сая төгрөг нийт 41.6 сая төгрөгийн цэвэр усны худаг болон бусад техникийг балансаас баланст шилжүүлэн авсан.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 11 дугаар сарын 29-ны өдрийн дугаар 39 тогтоолын дагуу анхны өртгөө нөхсөн 74.1 сая төгрөгийн хөрөнгийн үнийн шинэчлэн тогтоосон байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дугаар 46 тогтоолын дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3,424.3 сая төгрөгийн барилга байгууламж, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 54.2 сая төгрөгийн труба;

Аймгийн засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дугаар А/249 захирамжийн дагуу Сумын нэмэлт санхүүжилтийн хөрөнгөөр хийгдсэн 117.8 сая төгрөгийн барилга байгууламж тоног төхөөрөмж;

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн дугаар 79 тогтоолын дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 147.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийт 3,744.2 сая төгрөг хөрөнгийг хүлээн авч бүртгэсэн байна.

Тайлант онд 441.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан, 2.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн байна.

Тайлант онд аймгийн ИТХ-ын 2021 он оны 39, 42, 36, 40, 42, 56, 46 дугаар тогтоолын дагуу нийт 441.2 сая төгрөгийн өртөгтэй, 441.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 8 ширхэг хөрөнгийг данснаас хасаж, цаашид ашиглах боломжтой тул шинээр үнэлэн бүртгэлд тусгасан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 5,839.1 сая төгрөг байна. Богино хугацаат өр төлбөрт өмнөх оноос дамжин ирсэн 5,616.8 сая төгрөгийн урьдчилж орсон орлого байгаа нь нийт өр төлбөрийн 96.2 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр бэлтгэсэн хөрөнгийг урьдчилж орсон орлогоор бүртгэж, тайлан оны элэгдлийн хэмжээгээр бууруулан үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж байгаатай холбоотой байна.

Санхүүгийн тайланд өртөг, зардлын талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий удирдлага, борлуулалт маркетингийн зардал гэж ангилан бүртгэж, тайлагнасан байна. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг өмнөх онтой харьцуулахад 481.9 сая, ерөнхий удирдлагын зардал 88.6 сая, борлуулалт маркетингийн зардал 61.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь үйлдвэрлэл, үйлчилгээний нийт хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 24.8 сая төгрөгийн зээлийн хүүгийн зардлыг оруулан тооцсон байсныг завсрын аудитаар зөвлөмж өгч, залруулсан болно.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Ус-Ду” ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын баталсан 2021 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн дугаар 21/2021 хамтран ажиллах гэрээний дагуу “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,577.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,484.2 сая төгрөгөөр, 906.9 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 402.4 сая төгрөгийг төлөвлөсөн байна

Гүйцэтгэлээр 2,078.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,360.2 сая төгрөгийн зардал гарган, 54.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 2,078.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 830.9 сая төгрөг буюу 66.0 хувиар давахад тайлант онд төлөвлөгдөөгүй хөрөнгө оруулалтын болон татаас санхүүжилт болон зарим үйл ажиллагааны орлого орсон зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,360.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 123.9 сая төгрөг буюу 4.9 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь төлөвлөсөн их засварын зарцуулагдаагүй зардал болон цалин, НДШ-ийн зардлын хэмнэлтээс шалтгаалсан байна.

Тайлант онд алдагдал 54.8 сая төгрөг болж, төлөвлөсөн алдагдал буурсан байна. 54.8 сая төгрөгийн алдагдал нь борлуулалт маркетингийн болон удирдлага менежментийн өссөнтэй холбоотой байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 1,830.7 сая төгрөгийн 143 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 892.2 сая төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

5.2 Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3. "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг 2021 онд бүтэц, орон тоо, цалин санг шинэчлэн баталсан бөгөөд орон тоог цөөрүүлээгүй, ажилчдын цалинг 20-24%-аар нэмэгдүүлж, удаан жилийн нэмэгдэл олгох заалтад өөрчлөлт оруулж, цалингийн санг тогтоосон боловч “УС-ДУ” ОНӨААТҮГ-ын захирлын 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дугаар 89 тушаалын дагуу 8 ажилтанд 4.2 сая, 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дугаар 88 тушаалын дагуу 6 ажилтанд 3.1 сая, нийт 7.3 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн аудитын байгууллагын “Итгэмжлэл” авсан байна.

Завсрын аудитаар 1,177.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 572.2 сая төгрөгийг залруулж, 531.4 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 73.8 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

“Ус-Ду” ОНӨААТҮГ нь 2021 онд үндсэн хөрөнгийн дансанд нэмэгдсэн 3,872.4 сая төгрөгийн цэвэр ус түгээх худаг болон тоног төхөөрөмж бусад хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авсан, хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг хүлээн авсан, худалдан авсан тул дараагийн аудитаар хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүртгэл, ашиглалтад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,218.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,184.2 сая төгрөгийн алдааг залруулж, 7.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 26.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 26.6 сая төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон 42.0 сая төгрөгийн түвшнээс 15.4 сая төгрөгөөр бага байгаа тул “Зөрчилгүй дүгнэлт” өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,184.2 сая төгрөгийн 7 алдааг залрууллаа. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн тодруулга тайлан гаргуулсан,
- Орлогын дэлгэрэнгүй тайлан дахь харилцах дансны үлдэгдлийн хүүгийн орлогыг зөв ангилж бүртгээгүй,
- Санхүүгийн байдлын авлагын дүн тодруулга тайлангийн дүнгээс 67.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Засаг даргын баталсан зардлын төлөвлөгөөг дутуу илэрхийлсэн,
- Тайлант онд конторын 10.8 сая төгрөгийн халаалтын зардлыг ерөнхий удирдлагын зардалд хуваарилалгүйгээр шууд борлуулсан бүтээгдэхүүний өртөгт оруулж тооцсон,
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланг сангийн сайдын 361 дүгээр тушаалын дагуу бэлтгээгүй.
- БНХАУ-ын Эрээн хотоос байгууллагын үйл ажиллагааны орлогоос 299.1 сая төгрөгийн худалдан авалт хийж, байгууллагын бараа материалын дансанд орлогоор хүлээн авч тухайн байгууллага руу зарлагдаж, байгууллагын ББӨ-өөр тайлагнасан,
- Зээлийн хүүгийн зардлыг борлуулсан бүтээгдэхүүний өртгөөр бүртгэж, тайлагнасан,
- Ажилтны листний мөнгийг зохих зардлаас олгоогүй
- Орлогын дэлгэрэнгүй тайлан дахь борлуулалтын орлогын дүн нь Ebarimt.mn-д бүртгэсэн орлогын дүнгээс 251.6 сая төгрөгөөр, худалдан авалтын дүн мөнгөн гүйлгээний тайлангийн дүнгээс 318.6 сая төгрөгөөр тус тус дутуу илэрхийлэгдсэн
- Сэлбэгээр зарсан автомашины сэлбэгийн үнийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй,
- Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

8.2 Төлбөрийн акт байхгүй

8.3 Албан шаардлага

8.3.1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 143 мэдээлэл байршуулахаас 14 мэдээлэл хоцроож байршуулсан, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 4 дүгээр зүйлийн 4.1.3 заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан тул албан шаардлага өгөх

8.3.2 “УС-ДУ” ОНӨААТҮГ-ын захирлын 2021 оны 89 дугаар тушаалын дагуу 8 ажилтанд 4.2 сая, 2021 оны 88 дугаар тушаалын дагуу 6 ажилтанд 3.1 сая, нийт 7.3 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3. “.....цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага өгөх

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төлөвлөсөн зардлын зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Зарим зардлыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны баталсан дүнгээс хэтрүүлэн зарцуулсан ба шаардлагатай бол эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар зөвшөөрөл авч баталсан төлөвлөгөөний хуваарьт өөрчлөлт оруулаагүй байна. Тухайлбал, цахилгаан 17,352.9 мянга, усны төлбөр 4,881.8 мянга, холбоо 2,106.3 мянга, тээвэр шатахуун 2,270.3 төгрөгийн зардлууд хэтэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 3.1.6 дахь “.... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Ангилал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай тохиолдолд зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох албан тушаалтнаас зөвшөөрөл авч, төсөвт зохицуулалт хийлгэх

2. Төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүйгээс зарим зардал хүрэлцэхгүй өр төлбөр нэмэгдэх эрсдэл бий болсон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” заалтуудыг тус тус зөрчсөн, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөж, зарцуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөгөөр/

[illegible]

1	26,6
---	------

Говьсүмбэр аймаг дахь УС-ДУ ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

		тушаалтны баталсан дүнгээс хэтрүүлэн зарцуулсан ба шаардлагатай бол эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар зөвшөөрөл авч баталсан төлөвлөгөөний хуваарьт өөрчлөлт оруулаагүй байна.													
8		Төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүйгээс зарим зардал хүрэлцэхгүй өртөлбөр нэмэгдэх эрсдэл бий болсон	Төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөж, зарцуулж байх	1										1	
9		БНХАУ-ын Эрээн хотоос худалдан авалт хийж, байгууллагын бараа материалын дансанд орлогоор хүлээн авч тухайн байгууллага руу зарлагдаж, байгууллагын ББӨ-өөр тайлагнасан,		1	299.1	1	299.1								
10		Зээлийн хүүгийн зардлыг борлуулсан бүтээгдэхүүний өртгөөр бүртгэж, тайлагнасан		1	24.7	1	24.7								
11		Ажилтны листний мөнгийг зохих зардлаас олгоогүй		1	1.9	1	1.9								
12		Ebarimt.mn-д бүртгэсэн орлогын дүнгээс 251.6 сая төгрөгөөр, худалдан авалтын дүн мөнгөн гүйлгээний тайлангийн дүнгээс 318.6 сая төгрөгөөр тус тус дутуу илэрхийлэгдсэн		1	570.2	1	570.2								
13		Сэлбэгээр зарсан автомашины сэлбэгийн үнийг		1	0.5	1	0.5								

Говьсүмбэр аймаг дахь УС-ДУ ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй,												
14			Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.	1	208.5	1	208.5								
1,210.				7	1,210.8	5	1,184.2							2	26.6
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал															
1			Shilendans.gov.mn цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 14 мэдээлэл хоцроож байршуулсан нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж хангалтгүй хэрэгжсэнтэй холбоотой.	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан тул албан шаардлага өгөх	1						1				
2			“УС-ДУ” ОНӨААТҮГ-ын захирлын 2021 оны 89 дугаар тушаалын дагуу 8 ажилтанд 4.2 сая, 2021 оны 88 дугаар тушаалын дагуу 6 ажилтанд 3.1 сая, нийт 7.3 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон	Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага өгөх	1	7.3					1	7.3			
ДҮН				2							2	7.3			
НИЙТ ДҮН				9	1,218.1	5	1,184.2				2	7.3		2	26.6